



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 29 өдөр

Дугаар А/174

Ховд

Хөрөнгө гаргах, эрх шилжүүлэх тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн 2021 оны төсөв батлах тухай Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 3/03 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 4.22 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн 2021 оны төсөв батлах тухай Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 3/03 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 4.22 "Мал амьтны эрүүл мэндийг хамгаалах дэд хөтөлбөр"-өөс "Ховд олон улсын Нисэх онгоцны буудлын аэродромын хяналтын цэгээс 8км-ийн радиуст хийх агаарын хөлөг шувуу, мал амьтантай мөргөлдөх эрсдэлийг тогтоох тандалт судалгаа"-ны ажилд 3 320 800 төгрөг /Гурван сая гурван зуун хорин мянга найман зуу/-ийг зарцуулсугай.

2. Дээрх төсөл арга хэмжээнд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс зарцуулагдах 3 320 800 /Гурван сая гурван зуун хорин мянга найман зуу/ төгрөгийг санхүүжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт тус тус үүрэг болгосугай.

3. Тандалт судалгааны төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу шуурхай зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж, тайлагнаж ажиллахыг Ховд нисэх буудлын дарга /Г.Жаргал/-д зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ